

БУЛГАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2026/027/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Булган аймаг
2026 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Д.Батцогт
Утас: 70342716 Цахим хаяг: battsogtd@audit.gov.mn

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

“Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь
салбарын захирал: Д.Мягмарсүрэн
Утас: 99030170 Цахим хаяг: dalaivan.et@gmail.com

“Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь
салбарын Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 99921600 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580

Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026.02.24 № 124
танай _____ ны № _____ т

ХАНГАЛ СУМЫН ХЯЛГАНАТ
ТОСГОНЫ ЭМТ-ИЙН ДАРГА
Д.БОЛДБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны ЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хялганат тосгоны ЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хялганат тосгоны ЭМТ нь 2025 онд 282 хүн хэвтэн эмчлүүлсэн. Тайлант онд аймгийн Эрүүл мэндийн газраас 17,896.7 мянган төгрөгийн бараа материал, Эрүүл мэндийн яамнаас 16,135.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг мөн 3,496.8 мянган төгрөгийн бараа материал, 12,911.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хандив тусламжаар үнэ төлбөргүй орлогоор бүртгэж санхүүгийн тайланд тусгасан.

Аудитын гол асуудал

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор “Цалин хөлс шинэчлэн батлах тухай” төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосон байна.

2025 онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 03 Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай, 04 Жагсаалт, төлбөрийн

6326050063

хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай тогтоолуудад өөрчлөлт орсон байна. Тус Эрүүл мэндийн төв нь төвийн удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн хөгжил, эрүүл мэндийн санхүүжилт, эрүүл мэндийн мэдээллийн технологи, эм зүйн тусламж үйлчилгээ, эмнэлгийн тусламж үйлчилгээ гэсэн зорилттой тайлант оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, төсвийн хөрөнгийн ашиглалтын үр дүнг сайжруулах, зөв зохистой удирдах, өр, авлага үүсгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллахыг чиглэл болгосныг мөрдөж ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр нийт 9 зорилтын хүрээнд 66 арга хэмжээ хэрэгжүүлж ажиллан 92.6 хувьтай дүгнүүлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>172,826,083.93</u>	<u>91,912,894.55</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,187,384.08	16,779,613.30
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,187,384.08	16,779,613.30
3121	Төгрөг	1,187,384.08	16,779,613.30
31211	Төрийн сангийн харилцах	1,187,384.08	16,779,613.30
33	АВЛАГА	97,313,211.07	1,857,208.77
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	97,313,211.07	1,857,208.77
35	БАРАА МАТЕРИАЛ	74,325,488.78	73,276,072.48
351	Түүхий эд материал	59,334,714.78	53,691,921.94
35110	Тусгай зориулалтын материал	10,376,867.20	16,525,978.36
35130	Эм ороох боох материал	48,967,847.58	37,165,943.58
354	Хангамжийн материал	14,980,774.00	19,584,150.54
35410	Бичиг хэргийн материал	527,800.00	693,800.00
35420	Аж ахуйн материал	1,027,400.00	2,450,400.00
35460	Хүнсний материал	401,144.00	1,161,620.54
35470	Бусад хангамжийн материал	13,024,430.00	15,278,330.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>569,020,835.97</u>	<u>508,659,321.85</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	569,020,835.97	508,659,321.85
392	Биет хөрөнгө	539,246,210.97	479,025,321.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	298,173,500.11	304,345,249.39
39202	Хуримтлагдсан элэгдэл	(235,997,373.44)	(275,557,586.12)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	221,009,955.97	221,009,955.97
39204	Хуримтлагдсан элэгдэл	(26,845,833.39)	(59,638,137.47)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	306,134,397.89	311,052,075.89
39206	Хуримтлагдсан элэгдэл	(93,846,902.82)	(98,423,975.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	56,444,834.40	65,042,998.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,136,435.98)	(22,152,066.93)
39214	Бусад үндсэн хөрөнгө	38,449,616.06	40,112,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,215,448.83)	(7,961,792.46)
39217	Ном	1,075,901.00	1,195,901.00
393	Биет бус хөрөнгө	29,774,625.00	29,634,000.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(159,375.00)	(300,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	29,484,000.00	29,484,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>741,846,919.90</u>	<u>600,572,216.40</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>5,312,232.74</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	5,312,232.74
413	Өглөг	-	5,312,232.74
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	5,312,232.74
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>741,846,919.90</u>	<u>595,259,983.66</u>

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

51	Засгийн газрын хувь оролцоо	741,846,919.90	595,259,983.66
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	170,586,221.19	170,586,221.19
512	Хуримтлагдсан үр дүн	334,125,975.30	189,633,644.98
51210	Өмнөх үеийн үр дүн	334,125,975.30	336,220,581.22
51220	Тайлант үеийн үр дүн	-	(146,586,936.24)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	237,134,723.41	235,040,117.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>741,846,919.90</u>	<u>600,572,216.40</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,530,457,516.94	1,441,046,668.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	240,350,835.01	84,117,411.52
120	Нийтлэг татварын бус орлого	240,350,835.01	84,117,411.52
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	220,394,595.97	62,723,894.72
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	19,956,239.04	21,393,516.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,290,106,681.93	1,356,929,257.47
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131007	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,187,360.00	2,064,607.17
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	620,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	567,360.00	2,064,607.17
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	208,380,100.00	226,277,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	208,380,100.00	226,277,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,080,539,221.93	1,128,587,450.30
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,080,539,221.93	1,128,587,450.30
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,367,541,457.86	1,587,633,605.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,367,541,457.86	1,587,633,605.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,366,475,798.78	1,587,633,605.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	694,766,369.41	860,664,943.24
210101	Үндсэн цалин	341,586,862.36	389,157,264.99
210102	Нэмэгдэл	303,277,846.05	397,340,586.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,271,000.00	27,049,778.00
210104	Урамшуулал	33,630,661.00	47,117,314.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,250,039.50	108,010,158.11
210201	Тэтгэврийн даатгал	68,238,039.50	73,395,176.82

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	6,546,000.00	8,688,169.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,272,800.00	4,473,713.29
210204	Ажилгүйдлийн даатгал	3,272,800.00	4,379,484.89
210205	Эрүүл мэндийн даатгал	12,920,400.00	17,073,613.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	205,364,440.92	217,438,332.74
210301	Гэрэл, цахилгаан	11,691,386.25	15,189,096.74
210302	Түлш, халаалт	188,769,054.67	200,293,236.00
210303	Цэвэр, бохир ус	4,904,000.00	1,956,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,399,045.35	49,936,288.10
210401	Бичиг хэрэг	5,205,780.00	8,229,400.00
210402	Тээвэр шатахуун	17,177,944.70	23,146,943.20
210403	Шуудан холбоо, интернетийн зардал	1,247,200.00	1,404,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал хийх зардал	5,970,100.00	10,137,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	1,158,300.00	2,758,000.00
210408	Бараа материал акталсны зардал	7,639,720.65	4,260,044.90
2105	Нормативт зардал	141,451,517.60	128,156,086.20
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	120,291,720.60	108,400,582.24
210502	Хоол, хүнс	20,079,797.00	15,750,003.96
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	1,080,000.00	4,005,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,585,300.00	23,098,500.00
210604	Урсгал засвар	36,585,300.00	23,098,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,880,900.00	3,792,200.00
210702	Дотоод албан томилолт	2,880,900.00	3,792,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	62,687,630.30	23,438,198.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,909,244.30	22,817,510.00
210802	Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	1,449,500.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	42,500.00	42,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	45,00.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	352,500.00	355,300.00
210807	Газрын төлбөр	222,886.00	222,888.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	90,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,090,555.70	173,098,898.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,413,630.00	29,304,790.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	82,676,925.70	143,794,108.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,065,659.08	
2134	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,065,659.08	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,065,659.08	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	162,916,059.08	-146,586,936.24
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	162,916,059.08	-146,586,936.24

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<u>1,083,039,747.23</u>	<u>1,345,345,941.50</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,083,039,747.23	1,345,345,941.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,187,360.00	2,064,607.17
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	620,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	567,360.00	2,064,607.17
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	208,380,100.00	226,277,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	208,380,100.00	226,277,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	<u>873,472,287.23</u>	<u>1,117,004,134.33</u>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	873,472,287.23	1,117,004,134.33
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,260,610,965.11</u>	<u>1,416,084,330.55</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,260,610,965.11	1,416,084,330.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,259,545,306.03	1,416,084,330.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	694,766,369.41	860,664,943.24
210101	Үндсэн цалин	341,586,862.36	389,157,264.99
210102	Нэмэгдэл	303,277,846.05	397,340,586.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,271,000.00	27,049,778.00
210104	Урамшуулал	33,630,661.00	47,117,314.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,250,039.50	108,010,158.11
210201	Тэтгэврийн даатгал	68,238,039.50	73,395,176.82
210202	Тэтгэмжийн даатгал	6,546,000.00	8,688,169.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,272,800.00	4,473,713.29
210204	Ажилгүйдлийн даатгал	3,272,800.00	4,379,484.89
210205	Эрүүл мэндийн даатгал	12,920,400.00	17,073,613.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	205,364,440.92	212,126,100.00
210301	Гэрэл, цахилгаан	11,691,386.25	15,189,096.74
210302	Түлш, халаалт	188,769,054.67	194,981,003.26
210303	Цэвэр, бохир ус	4,904,000.00	1,956,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	<u>32,268,544.70</u>	<u>46,970,343.20</u>
210401	Бичиг хэрэг	5,377,600.00	8,245,400.00
210402	Тээвэр шатахуун	17,177,944.70	23,146,943.20
210403	Шуудан холбоо, интернетийн зардал	1,247,200.00	1,408,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал хийх зардал	5,920,000.00	9,670,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	2,545,800.00	4,500,000.00
2105	Нормативт зардал	<u>115,426,271.20</u>	<u>104,860,248.00</u>
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	96,260,211.20	81,418,367.50
210502	Хоол, хүнс	17,486,060.00	16,510,480.50
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	1,680,000.00	6,931,400.00

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,180,300.00	22,018,500.00
210601	Багаж техник хэрэгсэл	250,000.00	
210604	Урсгал засвар	39,930,300.00	22,018,500.00
2107	Томилолт зочны зардал	2,880,900.00	3,792,200.00
210702	Дотоод албан томилолт	2,880,900.00	3,792,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,243,740.30	24,127,678.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,465,354.30	23,386,990.00
210802	Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	1,449,500.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	42,500.00	42,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	45,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	352,500.00	355,300.00
210807	Газрын төлбөр	222,886.00	222,888.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	90,000.00	120,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,164,700.00	33,514,160.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,164,700.00	33,514,160.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,065,659.08	
2134	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,065,659.08	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,065,659.08	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-177,571,217.88	-70,738,389.05
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	24,339,200.00	20,708,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,339,200.00	20,708,700.00
	Дотоод эх үүсвэрээр	24,339,200.00	20,708,700.00
222001	Тоног төхөөрөмж	24,339,200.00	16,835,700.00
223001	Бусад хөрөнгө		3,873,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-24,339,200.00	-20,708,700.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-201,910,417.88	-91,447,089.05
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,187,384.08
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		16,779,613.30

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	20.... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз				
7	Тайлат үеийн үр дүн				
8					
9					
10	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	170,586,221.19	237,134,723.41	334,125,975.30	741,846,919.90
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			2,094,605.92	2,094,605.92
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-2,094,605.92		-2,094,605.92
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			-146,586,936.24	-146,586,936.24
18					
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	170,586,221.19	235,040,117.49	189,633,644.98	595,259,983.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,586,032,500.00	1,436,793,030.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,586,032,500.00	1,416,084,330.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,586,032,500.00	1,416,084,330.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	905,376,300.00	860,664,943.24
210101	Үндсэн цалин	394,613,600.00	389,157,264.99
210102	Нэмэгдэл	421,532,700.00	397,340,586.25
210103		27,230,000.00	27,049,778.00
210104	Урамшуулал	62,000,000.00	47,117,314.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,613,000.00	108,010,158.11
210201	Тэтгэврийн даатгал	75,579,200.00	73,395,176.82
210202	Тэтгэмжийн даатгал	9,008,500.00	8,688,169.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,504,200.00	4,473,713.29
210204	Ажилгүйдлийн даатгал	4,504,200.00	4,379,484.89
210205	Эрүүл мэндийн даатгал	18,016,900.00	17,073,613.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	211,792,800.00	212,126,100.00
210301	Гэрэл, цахилгаан	15,950,000.00	15,189,096.74
210302	Түлш, халаалт	193,176,400.00	194,981,003.26
210303	Цэвэр, бохир ус	2,666,400.00	1,956,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,548,700.00	46,970,343.20
210401	Бичиг хэрэг	8,377,600.00	8,245,400.00
210402	Тээвэр шатахуун	27,575,400.00	23,146,943.20
210403	Шуудан холбоо, интернетийн төлбөр	1,425,700.00	1,408,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, устгах, ариутгах	9,670,000.00	9,670,000.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	4,500,000.00	4,500,000.00
2105	Нормативт зардал	147,394,300.00	104,860,248.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	109,752,100.00	81,418,367.50
210502	Хоол, хүнс	29,567,200.00	16,510,480.50
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	8,075,000.00	6,931,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	66,595,300.00	22,018,500.00
210601	Багаж, техник хэрэгсэл	24,576,800.00	
210602	Тавилга	5,000,000.00	
210604	Урсгал засвар	37,018,500.00	22,018,500.00
2107	Томилолт зочны зардал	6,500,000.00	3,792,200.00
210702	Дотоод албан томилолт	6,500,000.00	3,792,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,816,500.00	24,127,678.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,460,700.00	23,386,990.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,000,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	42,500.00	42,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	50,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	387,900.00	355,300.00

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210807	Газрын төлбөр	222,900.00	222,888.00
210809	Улсын маягт хэвлэх, бэлтгэх	652,500.00	120,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,395,600.00	33,514,160.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,395,600.00	33,514,160.00
213	УРСГАЛ ЗАРДАЛ	-	
2132	Бусад урсгал шилжүүлэг		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		20,708,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	20,708,700.00
222001	Тоног төхөөрөмж	-	16,835,700.00
223001	Бусад хөрөнгө		3,873,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,470,451,600.00	1,345,345,941.50
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		2,064,607.17
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,064,607.17
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,064,607.17
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	225,943,800.00	226,277,200.00
132001	Орон нутгийн төсвөөс	225,943,800.00	226,277,200.00
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС		
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,243,320,400.00	1,117,004,134.33
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,243,320,400.00	1,117,004,134.33
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,187,400.00	
1200043	Урд оны үлдэгдлээс санхүүжих	1,187,400.00	
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,187,384.08
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		16,779,613.30

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны Эрүүл мэндийн төв нь харьяа нутаг дэвсгэрийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн төрийн үйлчилгээний байгууллага юм.

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Тайлант онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ өгөх, хянах, эрүүл мэндийг дэмжих, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэхэд орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд тулгуурлан эмнэлгийн анхан шатны тусламжийг үзүүлэхэд чиглэхийн зэрэгцээ 9 зорилтын хүрээнд 66 ажил төлөвлөн 92.6%-тай хэрэгжүүлсэн байна.

Эрхэм зорилго: “Тосгоны хүн амын эрт илрүүлгийн хамрагдалтыг 90 хувьд хүргэж, өвчлөлийг эрт үед оношилж, хавдрын шалгаант нас баралтыг бууруулах, эрүүл мэндийн ажилчдын ур чадварыг дээшлүүлж, чанартай тусламж үйлчилгээ үзүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шинэлэг хэлбэрээр зохион байгуулах” гэсэн зорилтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хялганат тосгоны Эрүүл мэндийн төв нь төвийн удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн хөгжил, эрүүл мэндийн санхүүжилт, эрүүл мэндийн мэдээллийн технологи, эм зүйн тусламж үйлчилгээ, эмнэлгийн тусламж үйлчилгээ, НЭМ-ийн тусламж үйлчилгээ зэрэг зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

2025 онд манай эмнэлэгт 282 хүн хэвтэн эмчлүүлсэн, 1974 ор хоног, 290.2 орны фонд ашиглалт, 6.8 дундаж ор хоног, 41.4 орны эргэлттэй байгаа нь өмнөх оноос эрс буурсан үзүүлэлттэй ЭМД-ын санхүүжилт буурсантай холбоотой байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хялганат тосгоны Эрүүл мэндийн төв нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, ЭМДҮЗ-өөс гаргасан тогтоолууд, НЭМ-ийн тухай хууль, эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 5, 6, 7 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоол, Сангийн сайдын 2024 оны А/50 дугаар тушаал болон эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль эрх зүйн акт, тогтоол, шийдвэр тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журам стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус байгууллага нь тайлант онд санхүү нягтлан бодох бүртгэлдээ дараах хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажилласан байна. Үүнд:

- Засгийн газрын 238 тогтоолоор “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээ”-г шинэчлэн тогтоож 2025 оны 01 сарын 1-ний өдрөөс мөрдлөг болгосон
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 03 (Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай), 04 (Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай) тогтоолд өөрчлөлт орсон байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээг цахимаар хянаж баталгаажуулснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол тосгоны төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичиг, зарлагын гүйлгээг хянан баталгаажуулан ажиллаж байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын дотоод хяналтын баг нь 2025 оны 01 сарын 06-ны өдрийн А/02 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан ба “Дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журам”-ыг боловсруулан ажиллаж байна.

Байгууллагын Дотоод хяналтын багийн ажиллах журмыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 6.4 заасны дагуу МУЗГ-ын 2011 оны 11 сарын 09 өдрийн 311 тогтоолыг үндэслэн боловсруулан, батлан, мөрдөн ажиллахаас гадна байгууллагын үйл ажиллагаанд "Дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журам"-ыг боловсруулан ажиллаж байна. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, НББ-д мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй хэвийн явагдсан байна. Дотоод хяналтын зүгээс тайлант онд санхүү ,нягтлан бодох бүртгэлтэй холбоотой хяналт , шалгалт хийгдээгүй байна.

Байгууллагын удирдлагын баг болон дотоод хяналтын багаас хэрэгжүүлж буй төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус Эрүүл мэндийн төв нь Булган аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн А/424 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж ажиллаж байна. Энэ нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч Эрүүл мэндийн тухай хууль, шинэчлэгдсэн журам, гүйцэтгэл, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн бүртгэлийн талаар тусгагдаагүй учраас тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан шинэчлэх шаардлага үүсэж байна.

Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг Си Ти Эс санхүүгийн программыг ашиглаж байна. Санхүүгийн программ нь Сангийн яаманд хүлээн зөвшөөрөгдсөн, төсвийн байгууллагын онцлогт тохирсон данс, бүртгэлийн системтэй бөгөөд УСНББОУС, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд нийцсэн иж бүрэн санхүүгийн тайланг бэлтгэхэд ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган аймгийн Хялганат тосгоны ЭМТөвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. 2025 оны 01 сараас эхлэн 2024 оны 12 сарын 25-ны өдрийн 238 тоот тогтоолоор цалингийн шатлалд өөрчлөлт орсон байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 141,274.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
1	Б	1	2	3=2-1
2	Мөнгөн хөрөнгө	1,187.5	16,779.6	15,592.1

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

3	Авлага	97,313.2	1,857.2	95,456.0
4	Бараа материал	74,325.5	73,276.1	1,049.4
5	Үндсэн хөрөнгө	569,020.8	508,659.3	60,361.5
Нийт хөрөнгө		741,846.9	600,572.2	141,274.7
7	Богино хугацаат өр төлбөр	0.0	5,312.2	5,312.2
8	Засгийн газрын хувь оролцоо /эздийн өмч/	170,586.2	170,586.2	0.0
9	Хуримтлагдсан үр дүн	334,125.9	189,633.6	-144,492.3
10	Дахин үнэлгээний нэмэгдэл	237,134.7	235,040.1	-2,094.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө, өмчийн дүн		741,846.9	600,572.2	141,274.7

Дээрх хүснэгтээс харахад нийт хөрөнгө өмнөх оноос 141,274.7 мянган төгрөгөөр буурахад авлага болон үндсэн хөрөнгийн данс нөлөөлсөн.

Тайлант оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 15,592.1 мянган төгрөгөөр өссөн байна. Нийт 1,345,345.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 1,329,753.6 мянган төгрөгийн зарцуулалт хийгдэж 16,779.6 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй байна.

Авлага өмнө оныхоос 95,456.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 73,276.1 мянган төгрөг болж 2024 оноос 1,049.4 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлангийн хугацаанд төсвийн хөрөнгөөр 205,753.2 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг хийж, 3,496.8 мянган төгрөгийн материалыг хандив тусламжаар авч, ХӨСҮТ болон Булган аймгийн ЭМГ-аас 17,896.7 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн орлогод авч, 220,958.6 мянган төгрөгийн материалыг зарцуулсан ба 7,237.5 мянган төгрөгийн бараа материалыг акталсан байна. Мөн 1,466.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байсан бараа материалын чанартай зүйлсийг бүртгэл хооронд шилжүүлэн авсан байна.

Үндсэн хөрөнгийн дансанд 16,135.1 мянган төгрөгийн хөрөнгийг ЭМЯам болон ХӨСҮТ-өөс үнэ төлбөргүй хүлээн авч, 12,911.2 мянган төгрөгийн хөрөнгийг хандив тусламжаар авч үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэж, улсын төсвийн хөрөнгөөр 12,304.0 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авч бүртгэлд тусгасан байна. Машин тоног төхөөрөмжийн дансанд дахин үнэлгээг хийж Булган аймгийн Төрийн өмчийн газрын даргын 2026 оны 01 сарын 15-ны өдрийн 01/11 албан тоотоор 9,816.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлгээнд хамруулан бүртгэн авсан. Тавилга эд хогшлийн дансанд 10,045.0 мянган төгрөгийн хөрөнгийг хандив тусламжаар орлогодон авч, улсын төсвийн хөрөнгөөр 5,434.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, 3,987.7 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж бүртгэн авсан байна. 1,466.1 мянган төгрөгийн бараа материалын шинж чанартай зүйлсийг үндсэн хөрөнгийн данснаас хасаж бараа материалын дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

Тайлангийн хугацааны санхүүжилттэй холбоотой байр ашиглалттай тогтмол зардал болох түлш халаалт дээр 5,312.2 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна. Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү нь 2,094.6 мянган төгрөг болж буурсан нь барилга байгууламжийн дахин үнэлгээтэй холбогдож байна. Цэвэр хөрөнгийн дүнд тайлангийн үеийн үр дүн алдагдалтай байж буурах нөлөөг үзүүлсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЭМДСангаас 1,403,088.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн

захирагчид хүргүүлсэн ба байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 243,792.8 мянган төгрөгөөр төлөвлөн орон нутгийн төрийн санд хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн санал 2025 онд 126,316.3 төгрөгөөр бууруулж 1,117,004.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт буурсантай холбоотой байна. Орон нутгийн санхүүжилтийн хувьд төсөвлөсөн саналаас 2025 оны 9 сард 10,000.0 мянган төгрөгийг хассантай холбогдон өглөг үүссэн болно.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Хялганат тосгоны ЭМТөв нь гүйцэтгэлийн санхүүжилтээр санхүүжиж 1 хөтөлбөр 4 зориулалт арга хэмжээний хүрээнд 1,243,320.4 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 1,117,004.1 мянган төгрөгийн санхүүжилтийг ЭМДСангаас авч, дээд шатнаас 2,064.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Орон нутгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр 1 хөтөлбөр 1 зориулалт арга хэмжээний зардалд 243,792.8 мянган төгрөгийг төсөвлөж 226,277.2 мянган төгрөгийн санхүүжилтийг аван зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71602-Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ					
1.1	80302-Нэг иргэн	948,904.8	897,609.4	51,295.4	94.59
1.2	81603- Үндсэн тусламж	295,603.0	230,578.4	65,024.6	78.0
1.3	83603-Дээд шатнаас хуваарилсан	99,393.4	81,837.5	17,555.9	82.3
1.4	83602-3г болон 3Д-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан	778.6	778.6	0.0	100.0
ОРОН НУТАГ УРСГАЛ САНХҮҮЖИЛТ					
1.1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	225,943.8	212,126.1	333.3	100.15

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд салбарын хэмжээнд нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан бөгөөд нэмэлт санхүүжилтийн дансаар ажил гүйлгээ хийгдээгүй, аваагүй болно.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй болно.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд зааснаар гэрээ шууд байгуулан ажилласан ба энэ нь Засгийн газрын 2024 оны 1 сарын 3-ны 02 дугаар тогтоолоор баталсан босго үнийг баримталсан.

Тайлант онд эмийн зардалд батлагдсан төсвөөс 81,418.4 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материалыг худалдан авсан ба цахим худалдан авалтыг шууд гэрээгээр хийсэн байна. Цахим худалдан авалтыг хийгээгүй шалтгаан нь цахим худалдан авалт хийх нөхцөл нь бүрдээгүй тус ЭМТөв нь 2025 оны 01 сарын 15-аас эхлэн

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан
удаа дараа нийт 5 удаагийн албан тоот холбогдох баримт, утсаар хэд хэдэн удаа, Any desk-ээр 2 удаа холбогдсон боловч нэвтэрч чадаагүй байна.

Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр, төрөл	Төрөл	Төсөвт өртөг (мян.төг)	Гэрээ байгуулсан дүн	Гэрээ байгуулсан этгээдийн нэр
Бичиг хэргийн зардал	Бараа	8,377.6	8,245.4	Ондоо принт ХХК,
Тээвэр шатахууны зардал	Бараа	27,575.4	23,146.9	Петровис ХХК,
Эд хогшил, урсгал засвар	Бараа	24,576.8	22,018.5	Гэрэлт цонх өөд ХК, ,
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	Бараа	109,752.1	81,418.3	
Хоол хүнс	Бараа	29,567.2	16,510.4	
Нормын хувцас, зөөлөн эдлэл	Бараа	8,075.0	7,827.2	Хялганат нар ХХК,
БГАХ	үйлчилгээ	27,816.5	24,127.6	
Дүн		235,740.6	183,294.3	

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны ЭМТөв нь тайлант онд төсвийн хөрөнгөөр нийт 183,294.3 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 20,708.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

- 3.6 Үндэсний аудитын газраас ирүүлсэн ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгааны үр дүнгийн талаар:**
- Байгууллагын даргын 2024 оны 06 дүгээр сарын 19-ний өдрийн А/40 дүгээр тушаалаар 5.0 мянган төгрөгөөр хоолны мөнгө тооцож олгосон байна.
 - Гадаад томилолт тухайн байгууллагад байхгүй.
 - Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал тайлант онд үүсээгүй.
 - Тус газар нь тайлант онд бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулсан.
 - Санхүүгийн программ хангамж нь 450.0 мянган төгрөгийн “Си-Ти-Эс” ХХК-тай гэрээ хийж ашигладаг
 - 210801- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж – тус данснаас тайлант хугацаанд 23,386.9 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.
 - 210901-Бараа үйлчилгээний бусад зардал ангилал 33,514.1 мянган төгрөг
 - Орон тооны судалгааны үр дүнгээс харахад нийт 52 орон тоо батлагдсан бөгөөд

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны ЭМТөвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Төсвийг зохистой удирдаж, зориулалтын дагуу зарцуулах, эд хариуцагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулах талаар болон Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Бэйкер тилли Далайван аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж анхан шатны чанарын хяналтыг салбарын захирал, аудитор Д.Мягмарсүрэн, хоёр дахь шатны чанарын хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Батцогт нар хэрэгжүүлэв.

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны ЭМТөвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн 1,367,541.4 мянган төгрөгийн нийт зардлаас 2 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 27,350.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 19,145.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2- 15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох, нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх, хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох зэрэгтэй холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй. Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээллээс дараах мэдээллийг түүвэрлэн шалгахад шалгалаа.

Илрүүлэлт: Шилэн дансанд 4 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1."мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Шийдвэрлэсэн: Шилэн дансанд мэдээлэх мэдээллийг Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан ба алдаа зөрчилтэй асуудал илрээгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны ЭМТөвийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн болно.

Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үндсэн хөрөнгө, бараа материалын биет тооллого, төсвийн орлого, зардлын зарцуулалттай холбоотой асуудлыг хянахаар тусгайлан авч үзсэн.

4.5.1 Завсрын аудитын талаар

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн болно. Дараах асуудлаар зөвлөмж өгсөн байна.

- Сахилгын шийтгэлтэй 3 ажилтанд 2,613.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон
- Албан хаагчийн томилолтоор ажилласан хугацаанд хоол, унааны нэмэгдлийг давхардуулан олгосон
- Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн 0 үлдэгдэлтэй хөрөнгүүд бүртгэлтэй байна
- Бараа материалыг буруу дансанд бүртгэсэн
- Эм эмнэлгийн материал дээр явцын биет тооллого хийхэд дутагдал үүссэн.

Завсрын аудитаар 5-н зөвлөмжийг өгсөн бөгөөд биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянан үзэхэд биелэлтийг хангаж ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.8, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д заасны дагуух заалтуудыг хэрэгжүүлээгүй гэсэн нийт 2 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	2	-	100%
Нийт дүн	2	-	2	-	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар илэрсэн зөвлөмж болон хүргүүлсэн асуудлуудын хэрэгжилт, худалдан авах ажиллагааны гэрээ, тендэр шалгаруулалт зэргийг анхаарч ажиллах хэрэгтэй гэж үзэж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулах 1 алдаа илэрч залруулан Санхүүгийн тайланг бэлтгэсэн болно. Санхүүгийн үр дүнгийн тайланд 1 810.1 мянган төгрөгийн бусад бараа ажил үйлчилгээний зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд гүйлгэн зарцуулсныг залруулсан.

Аудитаар нийт 2,613.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 2,613.1 мянган төгрөгийн төлбөрийн акт өгсөн.

Аудитаар залруулсан зөрчилтэй асуудал нь санхүүгийн тайланд нөлөөлөх магадлалгүй тул материаллаг багатай гэж үзэн өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн болно.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Явцын аудитаар сахилгын шийтгэлтэй 3 ажилтанд 2,613.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар бүлгийн 123.8 “Хөдөлмөрийн сахилгын шийтгэл оногдуулснаас хойш 1 жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын “Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох” журмын 2.7-д заасан “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэсэн заалтыг зөрчсөн байна.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй.

5.3 Зөвлөмж

Илрүүлэлт: Шилэн дансанд 4 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1. “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4 дүгээр зүйлийн 4.1.3. “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Шийдвэрлэсэн: Шилэн дансанд мэдээлэх мэдээллийг Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлж байх зөвлөмж өгсөн.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5. Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зардал гүйлгэн зарцуулсан	1	1810.1			1	1810.1	1	1810.1				
Дүн	1	1810.1			1	1810.1	1	1810.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан
/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Д үн	Тоо	Албан тушаалт ны тоо	Тоо	Дүн
Сахилгын шийтгэлтэй ажилтанд шагнал урамшуулал олгосон.	1	2,613.1	1	2,613.1								
Дүн	1	2,613.1	1	2,613.1		-						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээллийг хугацаа хоцроон мэдээллэсэн	1						1	
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1						1	